

ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН

ДЭРГЭДЭХ ГОМДЛЫН ШААРДЛАГЫН ЗӨВЛӨЛ

Орхон аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд “ Ажил олгогч, даатгуулагч болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөөг хянан шийдвэрлэх гомдлын шаардлагын орон тооны бус зөвлөл” ажилладаг. Үүнд:

Зөвлөлийн дарга:

Б.Анар Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

О.Пүрэвсүрэн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн орлого шимтгэлийн улсын байцаагч

Б.Ганзориг Аймгийн засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

С.Энхтүвшин Аймгийн засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч

Д.Эрдэнэбаяр Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

Б.Туяажаргал “Эрдэнэт үйлдвэр”ХХК-ийн Засвар угсралтын цехийнХүний нөөцийн менежер

Нарийн бичгийн дарга:

М.Дүүрэнжаргал Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалтын улсын байцаагч



Уг зөвлөл нь даатгуулагчийн гомдлыг хүлээн авч, 7 гишүүнтэйгээр ажлын шаардлага гарсан тухай бүрд хурал хийх бөгөөд нийгмийн даатгалын холбогдолтой хууль тогтоомж болон зөвлөлийн дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаар хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байсан хугацаагаар

тэтгэвэр тогтоолгохоор 7 иргэний өргөдөл, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгохоор 1 иргэн, үндсэн материалын овог нэр зөрүүтэй 2 иргэний өргөдлийг хэлэлцэж нийт 10 иргэний материалыг хэлэлцэн шийдвэрлэж 3 тогтоол гаргасан байна.

Тус хурлаар орж байгаа материалуудыг судалж үзэхэд хүний нөөцийн ажилтан, байгууллагын дарга нарын алдаанаас болж иргэний албан тушаалыг байгууллагын тушаалд буруу гаргасан, хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын

дэвтэрт буруу бичсэн зэрэг нийтлэг зөрчлүүд гарч байна. 2016 онд Гомдлын шаардлагын зөвлөлөөс “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хүний нөөцийн хэлтэст албан бичиг явуулсны дагуу тус байгууллага нь ажлын хэсэг томилон нэршил зөрсөн, орос тушаалаас алдаатай орчуулсан зэрэг зөрчлүүд дээр МХЕГ-ын дэргэдэх Хөдөлмөрийн нөхцөл хэмжилт судалгааны төвөөр дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.